


БАТЛАВ:  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН САНХҮҮ, ХАНГАЛТ,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА ДЭД  
ХУРАНДАА ..... / Я.ГАНТӨМӨР/



БАТЛАВ:  
МОН БУРДА /БГБХ/ нөхөрлөл  
РД: 2126079-тэй КЕНТАВР  
зочид буудал.  
захирал ..... /Ц.Төгөлдөр/

## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Дугаар №/43/

2020 оны 04 сарын 09 ны өдөр

Улаанбаатар хот

### Нэг. Гэрээний талууд

1.1 Энэхүү гэрээг нэг талаас .....; Онцгой байдлын ерөнхий газар.....; түүнийг төлөөлж тус

газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга, дэд хурандаа

Я.Гантөмөр /цаашид "Захиалагч" гэх/ нөгөө талаас МОН БУРДА /БГБХ/-ийн КЕНТАВР

зочид буудал түүнийг төлөөлж тус компаний нягтлан бодогч ажилтай /.....

/цаашид "Гүйцэтгэгч"

гэх, хамтад нь "Талууд" гэх/ нар харилцан тохиролцсоны үндсэн дээр дараах

нөхцөлтэйгөөр байгуулав.

### Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Энэхүү гэрээний зорилго нь "КЕНТАВР" зочид буудалд Захиалагчийн хүсэлтээр шинэ коронавирус (COVID-19)-ийн голомттой, дэгдэлт гарсан улс орноос ирсэн иргэдийг тусгаарлах, ажиглалтад авахтай холбоотой тусгаарлах үед байр, хоолоор хангах болон түүнтэй холбогдон гарах төлбөр тооцоог төлөхтэй холбогдсон харилцааг энэхүү гэрээгээр зохицуулахад оршино.

2.2. Гэрээний хугацаанд Талуудын өмчлөгч, эзэмшигч болон удирдлага өөрчлөгдсөн эсэхээс үл хамаарч энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

### Гурав. Захиалга хийх нөхцөл

3.1. Захиалагч нь тусгаарлах шаардлагатай хүмүүсийг зочид байрлуулахаас ажлын 3 хоногийн өмнө дараах мэдээллийн хамт өгнө. Үүнд:

Байр, хоолны төлбөр

Эхлэх болон дуусах огноо, цаг;

Хүний тоо /том хүн, хүүхэд/



/VIP/ зочин байгаа бол мэдэгдэх

Нэмэлт тусгай үйлчилгээ байгаа бол мэдэгдэх арга хэмжээг тус тус авна.

3.2 . Захиалагч энэхүү гэрээний 3.1-т заасны дагуу шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг зочид байрлуулахаас ажлын 3 хоногийн өмнө Зочид буудалд хүргүүлэх бөгөөд “Гүйцэтгэгч тал” бэлэн байдлыг хангаж тоног

Зочид буудлыг төлөөлж ..... Захиалагчийг төлөөлж

▲ төхөөрөмжийг /Өрөөний зохион байгуулалттай холбоотой нэмэлт ор, ширээ, сандал гэх мэт /цаашид “Тоног төхөөрөмж” гэх/ үнэ төлбөргүй ашиглуулна.

### **Дөрөв. Төлбөр, төлбөр төлөх нөхцөл**

4.1 . Гэрээний нийт үнийн дүн ..... /..... / төгрөг болно.

4.2 Энэхүү гэрээний төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дотор талууд тооцоо нийлж ..... банкны ..... тоот дансанд төлнө.

### **Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

5.1 Гүйцэтгэгч дараах эрхтэй:

▲ 5.1.1 Зочдын оруулж ирсэн тоног төхөөрөмж, эд зүйлсийн чанар гэмтэл, түүнээс үүсэх үр дагаврыг хариуцахгүй;

5.1.2 Зочид эмх замбараагүй үйлдэл хийх, архидан согтуурах, танхайрах зэргээр зочид буудлын бусад зочид, үйлчлүүлэгчийн ая тухтай байдалд нөлөөлөхүйц үйлдэл гаргасан тохиолдолд захиалагч талд нэн даруй мэдэгдэн энэ үйлдлийг зогсоохыг шаардах, шуурхай арга хэмжээ авахуулах;

5.2 Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

5.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ Монгол Улсын хууль, тогтоомж, зочид буудлын дотоод дүрэм, журамд /Бэлэн байдлын зэрэгт шилжсэн/ нийцүүлэн хэрэгжүүлж, биелүүлэх;

5.2.2 Захиалагчаас ирүүлсэн зочид буудалд байрлах иргэдийн сахилга бат, эрүүл мэндийн дэглэм сахих нарийвчилсан зааврыг урьдчилан авч бэлэн байдлыг ханган, зочид байрлах явцад мөрдөх;

▲ 5.2.3 Зочид буудлын ажилтан, үйлчлэгч нарыг халдвар хамгааллын хэрэгслээр хангах;

5.2.4 Захиалагчтай тохиролцсон хоолны цэсний дагуу эрүүл ахуйн стандартад нийцсэн, амт чанар сайтай зоогоор үйлчлэх;

5.2.5 Захиалагчийн өгсөн зааврын дагуу хоолыг эрүүл ахуйн өндөр дэглэмийн дор өрөө өрөөнд нь түгээх;

5.2.6 Өрөө тасалгаа, гал тогоо, ариун цэврийн өрөөг тусгай зориулалтын



ариутгалын бодисоор цэвэрлэж, ариутгал халдваргүйжүүлэх ажлыг зааврын дагуу хийх;

5.2.7 Зочид байрлах хугацаанд захиалагч талаас өгсөн удирдамж зааврыг мөрдөн, захиалагчийн зөвшөөрөлгүй гаднаас эд зүйлс оруулахгүй байх;

5.2.8 Захиалагчийн төлөөлөгчийг байлцуулан зочид байрлах өрөөнүүдийг цэвэрлэж, түгжин хүлээлгэн өгөх /хүлээлцсэн баримт үйлдэн/;

5.2.9 Зочид байрлах үеэр саад болох засвар, сайжруулалт хийх ажлыг зөвхөн давагдашгүй хүчин зүйлээс бусад тохиолдолд хийхгүй байх;

Зочид буудлыг төлөөлж ..... Захиалагчийг төлөөлж

5.2.10 Захиалагч урьдчилан захиалсан тохиолдолд энэхүү гэрээний 3.2-т заасан тоног төхөөрөмжөөр үйлчлэх;

5.2.11 Тоног төхөөрөмжийг Зочид буудлаас "Хүлээлцэх хуудас" гарган хүлээлгэн өгч, мөн хуудсын дагуу хүлээн авах,

5.2.12 Зочид буудалд байрласан зочдын үлдээсэн, мартсан эд зүйлсийг хадгалан эзэнд нь буцааж өгөх, эсхүл Захиалагчид хүлээлгэн өгнө.

Зургаа. Захиалагчийн эрх, үүрэг

### **6.1 Захиалагч дараах эрхтэй:**

6.1.1 Захиалагч тал нь гүйцэтгэгч талаас үйлчилгээний чанар стандарт, болон шаардлагатай бэлэн байдлыг шаардах эрхтэй.

6.1.2 Гэрээний үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээллийг шаардах эрхтэй.

6.2 Захиалагч дараах үүргийг хүлээнэ:

6.2.1 Зочид буудлын дотоод журам, Монгол Улсын хууль, тогтоомжид захирагдах;

6.2.2 Гэрээний хугацаанд гуравдагч этгээдээр гэрээт үйлчилгээг хийлгэх тохиолдолд Зочид буудалд энэхүү үйлчилгээний талаар нарийвчилсан мэдээллийг бичгээр өгөх, гуравдагч этгээдийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг өөрөө хариуцах;

6.2.3 Зочид буудлын эзэмшил газруудад зөвшөөрөлгүй гаднаас хоол, хүнс болон согтууруулах ундааны төрлийн зүйл оруулахгүй байх;

6.2.4 Зочид байрлахаас өмнө өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний бэлэн байдалтай биечлэн танилцах;

### **Долоо. Гэрээ цуцлах**

7.1 Дараах тохиолдолд Гүйцэтгэгч талын санаачлагаар гэрээг цуцлана.

7.1.1 Захиалагч нь энэхүү гэрээнд заагдсан нөхцлүүдийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гүйцэтгэгч талын санаачлагаар гэрээг цуцалж болно.

7.2 Гэрээг цуцлах талаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

Найм. Давтагдашгүй хүчин зүйл



8.1 Гэрээнд оролцогч талуудаас үл хамаарах байгалийн үзэгдэл, төрөөс явуулж буй бодлого /хууль, эрх зүйн акт/, нийгмийн хямрал зэрэг шалтгаанаар талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар 24 цагийн дотор бие биедээ мэдэгдэх үүрэгтэй бөгөөд түүний улмаас ямар нэгэн хор хохирол учирсан тохиолдолд аль аль нь хариуцлага үл хүлээнэ.

#### ▲ Ес. Маргаан шийдвэрлэх, бусад

Зочид буудлыг төлөөлж ..... Захиалагчийг төлөөлж

9.1 Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж талууд гэрээний үүргээ зохих ёсоор бүрэн биелүүлснээр гэрээ дуусгавар болно.

9.2 Гэрээгээр зохицуулаагүй талуудын хоорондын бусад харилцааг энэхүү гэрээнд заасан нөхцөл, зарчмын хүрээнд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохицуулна.

9.3 Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд юуны түрүүнд хэлэлцэн тохиролцох замаар эрмэлзэх бөгөөд хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4 Хэрэв захиалагчийн зочид дунд онцгой зэрэглэлийн зочин ирсэн тохиолдолд энэхүү гэрээний 3.1-т заасны дагуу Зочид буудалд урьдчилан мэдэгдэх ба зочны мэдээллийг нууцлах тал дээр талууд хамтран ажиллана.

9.5 Гэрээний хугацаа дууссан, гэрээ цуцлагдсан нь талуудын төлбөр, алданги, торгууль, хохирол төлөх үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

9.6 Талууд аль нэг талдаа санал гаргах, гэрээнд өөрчлөлт оруулах тухай саналаа зөвхөн бичгээр хүргүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: ЭМНЭЛГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа:

..... Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот

Утас: .....

Факс: .....

Имэйл: .....

Цахим хуудас: .....

